



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,  
Факс: (976-11) 45 86 99, И-мэйл: info@nccd.gov.mn,  
Вэбсайт: www.nccd.gov.mn

2020.12.01 № 7/55  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗАР, СУМ, ДҮҮРГИЙН  
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД,  
НЭГДСЭН ЭМНЭЛГҮҮД, ЛАВЛАГАА  
ТӨВҮҮДЭД

**Түр зөвлөмж хүргүүлэх тухай**

Дэлхий дахинд шинэ коронавируст халдварын цартахал нь 218 улсыг хамран тархаж, 2020 оны 11 дүгээр сарын 29-ний байдлаар 61 гаруй сая хүн өвчилж, нас баралтын 1,4 сая тохиолдол бүртгэгдээд байна. Манай улсад 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хот болон 6 аймагт дотоодын халдвар бүртгэгдлээ.

Томуугийн харуулдан тандалтын одоогийн тогтолцоонд суурилан шинэ коронавируст халдварын тандалтыг өргөжүүлэн зохион байгуулж, халдварын тохиолдлыг эрт илрүүлэх, хүндрэл эндэгдлээс урьдчилан сэргийлэхийг ДЭМБ зөвлөмж болгож байна.

Манай улсын хувьд томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд амбулаторид суурилсан 115, эмнэлэгт суурилсан 37 нэгж хамрагдан жилийн турш томуу, томуу төст өвчин (ТТӨ), амьсгалын замын цочмог хүнд халдвар (АЗЦХХ) -ын тандалтыг хийж, тохиолдлын тодорхойлолтонд тохирсон өвчтөнийг бүртгэн мэдээлж, хамар залгиурын арчдас цуглуулан, шинжилдэг.

Иймд томуугийн тандалтыг өргөжүүлэн, нэгжийн тоог нэмэгдүүлэн зохион байгуулж, дараахи тохиолдлын тодорхойлолтонд тохирсон тохиолдлын тоог мэдээлэх, өвчтөнөөс ЭМС-ын 2014 оны 358 тоот тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу сорьц цуглуулан, зөв хадгалан, ХӨСҮТ-ийн Вирус судлалын лаборатори болон холбогдох лабораторид хугацаанд нь тээвэрлэн хүргүүлнэ.

**Тохиолдлын тодорхойлолт: (ДЭМБ-2013)**

**ТТӨ:** Сүүлийн 10 хоногт гэнэт 38 хэм, түүнээс дээш өндөр халуурах, ханиалгах зэрэг эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн амьсгалын замын цочмог халдварын тохиолдлыг хэлнэ (J00-J22).

**АЗЦХХ:** ТТӨ-ий шинж тэмдэг бүхий өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай тохиолдлыг хэлнэ (J00-J22).

**Голомтолсон өвчлөл:** Нэг хамтлаг, хамт олны дунд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд эмнэлзүйн адил шинж тэмдэг гэнэт илрэхийг хэлнэ

**Шинэ коронавируст халдварын сэжигтэй тохиолдол: (ДЭМБ-2020)**

**А.**

**Эмнэлзүй, эпидемиологийн шалгуур үзүүлэлт тохирсон тохиолдол:**

**Эмнэлзүйн шалгуур үзүүлэлт:**

Гэнэт халуурах, ханиалгах

**ЭСВЭЛ:**

Дараахи шинж тэмдгээс дор хаяж ГУРАВ нь:

Халуурах, ханиалгах, тамирдах/ядрах, толгой, булчин, хоолой өвдөх, хурц ханиалгах, амьсгал тасалдах, хоолны дуршил буурах/дотор муухайрах/бөөлжих, суулгах, сэтгэл санаа өөрчлөгдөх, үнэрлэх, амтлах мэдрэхүй алдагдах;

**БА:**

**Эпидемиологийн шалгуур үзүүлэлтүүд:**

Вирус тархах өндөр эрсдэлтэй нутаг оронд шинж тэмдэг эхлэхээс өмнөх 14 хоногийн хугацаанд ажилладаг, амьдардаг: асрамжийн газар, орон гэргүй хүмүүст зориулсан хүмүүнлэгийн түр оршин суух газар; ЭСВЭЛ шинж тэмдэг эхлэхээс өмнөх 14 хоногийн хугацаанд хүн амын дунд тархалттай нутагт амьдарч байсан эсвэл зорчсон;

**ЭСВЭЛ**

Шинж тэмдэг эхлэхээс өмнөх 14 хоногийн хугацаанд эмнэлэг эрүүл мэндийн байгууллага эсвэл хүн амд ямар нэг эрүүл мэндийн тусламж үзүүлдэг байгууллагад ажилладаг өгүүлэмжтэй.

**Б.**

Халуурах (халууныг үзсэн болон тэмдэглэгээ)+ ханиалгах эсвэл амьсгалахад бэрхшээлтэй болох+эмнэлэгт хэвтсэн тохиолдлыг хэлнэ.

Хүснэгт 1. Шинэ коронавируст халдвар, ТТӨ, АЗЦХХ-ын тандалтанд нэмэлтээр хамрагдах хилийн боомттой аймаг, сумд, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд

1. Өргөжүүлсэн тандалтанд хамрагдах хилийн боомттой аймаг, сумдын нэрс

№	Нэгжийн нэрс (аймгаар)	Хилийн боомтын нэрс	Сорьц хүргэх лабораторийн байршил	Сумдын нэрс
1	Баян-Өлгий	Цагааннуур	Ховд аймаг	Цагааннуур
2	Дорноговь	Замын-Үүд	Замын-Үүд сум	Замын-Үүд
		Ханги		Хатанбулаг
3	Дорнод	Хавирга	Дорнод аймаг	Чойбалсан
		Эрээнцав		Чулуунхороот
		Баянхошуу		Халх гол
4	Өмнөговь	Гашуунсухайт	Улаанбаатар	Ханбогд
		Шивээхүрэн		Гурван тэс
5	Сүхбаатар	Бичигт	Улаанбаатар	Эрдэнэцагаан
6	Сэлэнгэ	Алтанбулаг	Сэлэнгэ аймаг	Алтанбулаг
		Сүхбаатар		Сүхбаатар
7	Увс	Боршоо	Ховд аймаг	Давст
8	Ховд	Булган	Ховд аймаг	Булган
9	Хөвсгөл	Ханх	Улаанбаатар	Ханх

- Өргөжүүлсэн тандалтанд хамрагдах эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа амаржих газрууд нэмэлтээр хамрагдана.
- ЭМС-ын 2014 оны 358 тоот тушаалын 1 дүгээр хавсралтанд заагдсан томуугийн харуулдан тандалтын нэгжүүд нь шинэ коронавируст халдварын сэжигтэй болон ТТӨ, АЗЦХХ-ын тандалтыг зохион байгуулна.
- Тандалтын нэгжүүд нь шинэ коронавируст халдварын сэжигтэй болон ТТӨ, АЗЦХХ-ын тохиолдол бүрээс сорьц цуглуулж, ЭМС-ын 2020 оны А/482 тоот тушаалын дагуу өдөр тутам болон долоо хоногийн мэдээг веб-д суурилсан томуугийн мэдээллийн системээр мэдээлнэ.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.НЯМХҮҮ